

**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04-р сарын 21-ний өдөр

Дугаар 26/01

Улаанбаатар хот

Хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 21-ний өдрийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр гэж тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04-р сарын 21-ний өдөр

Дугаар 26/02

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.9 дахь заалт, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид “Компани” гэх) -ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 21-ний өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 03/02 дугаар тогтоолын хавсралтаар батлан гаргасан дүгнэлтийг сайшаан баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04-р сарын 21

Дугаар 26/03

Улаанбаатар хот

*ТУЗ-ийн гишүүдийг сонгох
болон ТУЗ-ийн зардлын төсвийг
батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид “Компани”гэх) -ийн Дүрмийн 7-р зүйлийн 7.8.7 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 30-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнээр сонгож баталсугай.

Хараат бус гишүүд: Г.Бэхбат, Н.Монсор, Ж.Дэлгэрсайхан, Ц.Баярбаатар;

Ердийн гишүүд: Б.Эрдэнбилэг, Н.Эрдэнэбат, Т.Энхмэнд, С.Нэргүй, Ц.Хангай.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БЭХБАТ